

МЭРГЭЖИЛТЭН СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР

ТАНИЛЦУУЛГА

Тусгай Мэргэжилтэн Солилцооны Хөтөлбөр (ТМСХ) нь БНХАУ/ Хонг Конг/ Тайван/ Монгол Улс дахь төрийн бус байгууллагуудад ажиллаж буй мэргэжилтнүүдэд зориулсан солилцооны хөтөлбөр юм. Уг хөтөлбөрт хамрагдснаар Америкийн Нэгдсэн Улсын (АНУ) төрийн бус салбарын мэдлэг, туршлагаас суралцан, дадлага хийх боломжтой.

Хөтөлбөр эхлэхээс өмнө шалгарсан оролцогчид цахим бэлтгэл сургалтад хамрагдаж Бээжин /Хонг Конг /Улаанбаатар/ Тайпэй хотод зохиогдох нэг өдрийн хөтөлбөрийн танилцуулга үйл ажиллагаанд оролцоно. Хөтөлбөрийн танилцуулга үйл ажиллагааны дараа АНУ-ын Вашингтон хот руу зорчин, нээлтийн үйл ажиллагаанд оролцон, хөтөлбөрийн үндсэн хэсэг болох дөрвөн долоо хоногийн дадлагын ажлыг холбогдох байгууллагад эхлүүлнэ.

Хөтөлбөрийн оролцогч нь дадлагын үеэр хөтөлбөрийн түнш байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох буюу байгууллагын ажилтанд дагалдах, хурал уулзалтад суух зэргээр оролцох бөгөөд дадлагын төгсгөлд Сан Франциско хотод зохион байгуулагдах 4 өдрийн хаалтын үйл ажиллагаанд оролцсоноор АНУ дахь үйл ажиллагаа өндөрлөнө. Оролцогчид эх орондоо ирсний дараа өөрийн боловсруулсан төслийг бие даан хэрэгжүүлэх шаардлагатай. Түүнчлэн 2023 онд АНУ-д хүлээж авсан түнш байгууллагын ажилтнууд БНХАУ/Хонг Конг/ Тайван/ Монгол Улсад зочилж туршлага солилцсоноор энэ жилийн хөтөлбөр өндөрлөнө.

Хөтөлбөрийн оролцогч бүр өөрийн бие даасан төслийг хэрэгжүүлэх шаардлагатай ба төслөө хөтөлбөрийн туршид сурсан зүйлс дээрээ үндэслэн боловсруулна. Уг төслийг заасан хугацаанд багтаан хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд олон хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой. Үүнд: судалгааны ажил, өөрийн ажиллаж буй байгууллагадаа шинэ төсөл/хөтөлбөр санаачлах, ажил гүйцэтгэх шинэ арга барил нэвтрүүлэх, цуврал лекц зохион байгуулах зэрэг өөрийн ажлын онцлогт зохицсон хэрэгцээтэй төсөл хэрэгжүүлж болно. Төслийн санал тухайн орны нөхцөл байдалд нийцсэн, шинэлэг, нийгэмд хэрэгтэй байхыг чухалчилна. Төслийн санааг дэлгэрэнгүй, тодорхой бичиж ирүүлэх шаардлагатай.

Анхааруулга: Уг хөтөлбөр нь цахим болон биеэр хослон хэрэгжих бөгөөд АНУ- руу явах хүртэл үйл ажиллагаа цахимаар зохион байгуулагдана. АНУ – д хийх дадлага нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалахыг анхаарна уу. Цар тахлын нөхцөл байдлаас үүдэж солилцооны үйл ажиллагаанд хүндрэл учирсан тохиолдолд хөтөлбөрийн аялын хэсэг хойшилох, цуцлагдах, эсвэл цахим хэлбэрт шилжих магадлалтай. Энэхүү шийдвэр нь тухайн улс болон нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн бодлого зохицуулалтад нийцүүлж шийдвэрлэгдэнэ.

ХӨТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

2025 оны 1-3-р сар

Цахим уулзалт

- Мэргэжил, хөгжлийн сургалтууд
- Багаар ажиллах арга хэмжээ

2025 оны 3-р сар

Хөтөлбөрийн танилцуулга үйл ажиллагаа, Бээжин/Хонг Конг/ Улаанбаатар/Тайпэй

- Аялын бэлтгэл
- Хөтөлбөрийн хүлээлт

2025 оны 4-р сарын 2-5

Хөтөлбөрийн танилцуулга үйл ажиллагаа, Вашингтон ДиСи

- АНУ-ын төрийн бус салбарын танилцуулга
- Хөтөлбөрийн танилцуулга
- Багаар ажиллах арга хэмжээ

2025 оны 4-р сарын 7-ноос 5-р сарын 5

- АНУ-ын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанаас суралцан, Америк хамт олонтой туршлага хуваалцаж, мэдээлэл солилцоно

2025 оны 5-р сарын 5-9

Төгсгөлийн үйл ажиллагаа

- Хөтөлбөрийн үнэлгээ
- Зөрчилдөөний менежмент/соёл хоорондын харилцааны сургалт

Төсөл

- Хөтөлбөрөөс сурсан мэдлэгээ ашиглан өөрийн улсдаа төсөл хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрт оролцогчдод тавигдах шаардлагага:

- **Байгаль орчин, халамж, хууль зүйн зөвлөгөө, нийгмийн хөгжлийн чиглэлээр төрийн бус байгууллагад ажиллаж буй 25-40 насны** мэргэжилтэн байх. Нийгмийн бусад салбарт амжилттай ажиллаж буй өргөдөл гаргагчдын хүсэлтийг мөн харгалзан үзнэ. Төрийн албан хаагч болон эрдэм шинжилгээний байгууллагын ажилчдын материалыг хүлээн авах тоо хязгаартай.
- **Англи хэлний бичгийн болон ярианы зохих мэдлэгтэй байх** (АНУ-д бие даан ажиллаж, амьдрах чадвартай)
- **Хөтөлбөрийн төгсгөлд эх орондоо буцаж ирсний дараа төсөл хэрэгжүүлэх чин хүсэлтэй байх**
- **Мэргэжлийн өндөр ур чадвартай байх**
- **Бие даан 5-6 долоо хоногийн дадлага ажлыг гүйцэтгэх чадвартай байх**
- **АНУ-д 3 сараас дээш хугацаанд ажиллаж, амьдраагүй байх**

АНУ- БНХАУ Харилцааг Эрхэлсэн Үндэсний Хороо хөтөлбөрт оролцогчдын виз авах, аялах болон түр оршин суух байрны асуудлуудыг шийдэхэд хамтран ажиллана. Хөтөлбөрийн турш оролцогчид дотуур байр, айлд байрлах, орон сууц хамтран түрээслэх зэрэг хэлбэрээр АНУ-д байрлана. Хөтөлбөрт хамрагдах бүх зардлыг хөтөлбөр зохион байгуулагч хариуцна.

Хөтөлбөрийн өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа: 2024 оны 3-р сарын 1.

[УГ ХӨТӨЛБӨРИЙГ](#) АНУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОВСРОЛ, СОЁЛЫН ГАЗРЫН ДЭМЖЛЭГТЭЙГЭЭР АНУ-БНХАУ ХАРИЛЦААГ ЭРХЭЛСЭН ҮНДЭСНИЙ КОМИСС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА.